



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал дэн буудалд тавих ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Доун ХХК-ний “Романс” зочид буудлын 16/081, Их алтай трейд ХХК-ний “Алтай” зочид буудлын 17/020, Рич холдинг ХХК-ний “Рич” зочид буудлын 16/166, Голден саякэл Эшиа пэсифик ХХК-ний “Мийтинг корнер” дэн буудлын 16/088, Эм эс энд ти эс ХХК-ний “Эм эс энд ти эс” дэн буудлын 13/285, ЭДД ХХК-ний “Гарьд” дэн буудлын 16/086, Хан толт ХХК-ний “Атила” дэн буудлын 17/028, гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 02 сарын 11  
өдрийн 8:00 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.02.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистраийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Очирхөгжих ХХК	5626307	Их баян	БГД-ийн 20-р хороо Москва 54 тоот
2	Дорномандал Мами ХХК	4555805	Мами	БНД-ийн 3-р хороо Наран хороолол 39/1
3	Доун ХХК	2009234	Романс	БНД-ийн 3-р хороо Нацагдоржийн гудамж 55
4	Их алтай трейд ХХК	2565595	Алтай	БГД-ийн 9-р хороо Хасбаатарын гудамж
5	Рич холдинг ХХК	5621820	Рич	БГД-ийн 22-р хороо зүүн наран 18/49
6	Талын Монгол групп ХХК	2692058	Оффис хотел	БГД-ийн 16-р хороо Орхоны 1-дүгээр гудамж 19
7	Цогт зөвлөн ХХК	5972418	Цогт зөвлөн	СХД-ийн 19-р хороо 1-99 тоот
8	Голден лайт хоспиталити ХХК	2672715	Стрийт 63	БЗД-ийн 6-р хороо ЭТӨЧ 63 байр

--ооОоо--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 02 сарын 11  
өдрийн дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.02.14

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Голден саякэл Эшия пэсифик ХХК	5271142	Мийтинг корнер	СХД-ийн 20-р хороо Сонсголонгийн зам 32 тоот
2	Эм эс энд ти эс ХХК	2805006	Баянгол	БГД-ийн 8-р хороо Ард Аюушын өргөн чөлөө 20
3	ЭДД ХХК	5272807	Гарьд	СХД-ийн 8-р хороо Баянхшуу 74
4	Хан тольт ХХК	5498732	Аттила	СХД-ийн 4-р хороо 78 тоот
5	Агнай ХХК	2113961	Эра	БЗД-ийн 1-р хороо ЭТӨЧ 20/5
6	Истим ХХК	6039081	Лонг лайф	БГД-ийн 8-р хороо 4-р хороолол 7-р байр 1-2
7	Ти зүүм ХХК	5916186	Жое	СБД-ийн 3-р хороо 5-р хороолол 13-8

--ooOoo--